

МОНГОЛ ОРОН
MONGOLIA

МОНГОЛ ОРОН MONGOLIA

МОНГОЛ ОРОН
MONGOLIA

МОНГОЛ ОРОН
MONGOLIA

MONGOLIA

Mongolian People's Republic

A Photobook

Planeta Publishers,
Moscow, 1983

State Publishing House
of the Mongolian People's Republic,
Ulan Bator, 1983

МОНГОЛ ОРОН

Бүгд Найрамдах Монгол Ард Улс

Гэрэл зургийн альбом

«Планета» хэвлэлийн газар
Москва, 1983

Улсын хэвлэлийн газар
Улаанбаатар, 1983

© Planeta Publishers, 1983

Монголд ардын нам байгуулсан нь ард түмний тэмцэлд амжилт олохын нөхцөл мөн.

В. И. Ленин

Бидний улс эв саналаа нэгтгэн нийтийн нэгэн хүчийг нийлүүлэн нэгэн зэргээр зориглон хөдөлбөөс үл хүрэх газаргүй бөгөөд мэдэхгүй чадахгүй хэмээх явдал огт үгүй болж цэнгэлийн манлайг олж болохыг дан ганц бидний сэтгэлийн чин зориг мэднэ.

Д. Сүхбаатар

The organization of a political party of Mongolian arats is essential for success in their struggle.

Vladimir Lenin

If we, our entire people, unite in one common desire, in one common resolve, there is nothing in the world we cannot achieve, nothing we cannot know, nothing we would not be able to do.

Damdiny Sukhe-Bator

Алтай Хянган хоёрын завсарт
атар баялаг орон
Аав ээжийн минь оршсон
ашдын заяасан нутаг
Алтан нарны туяанд
энхжин тогтсон орон
Мөнгөн сарны гэрэлд
мөнхжин гялалзсан газар.

Д. Нацагдорж

From Khingan to Altai my country ranges;
Firmly united with her throughout the ages
My people, above whom today there proudly waves
The Red Flag, like sun in sky gloriously ablaze!

D. Natsagdorzh



Мартагдашгүй уулзалт. Зураач Н. Чүлтэм An Unforgettable Meeting. *By N. Chultem*

Сүхбаатар
Зураач Ү. Ядамсүрэн

D. Sukhe-Bator.
By U. Yadamsuren

Монгол бол байгаль, цаг уурын хувьд гайхмаар эрс тэс ялгаа бүхий, эр зоригтой, хөдөлмөрч, тунчиг даруу, сэтгэл цагаан хүмүүстэй орон билээ. Өнө эртний түүхтэй боловч, хамгийн яруу тод, сэтгэл хөдөлгөсөн үе нь өнөө цагт хамаарна.
1917 оны аравдугаар сард оросын пролетари нарын ялалттай Дорно дахины ард түмний дотроос хамгийн түрүүн дуу дуугаа авалцан сэргэсэн ард түмний нэг болсон Монголын жинхэнэ цэцэглэлт нь 1921 оны ардын хувьсгалын дараа эхэлсэн юм. Аугаа Октябрийн үзэл санаа монголын ард түмний ангийн ухамсрын хөгжлийг хурдасгаж, сорон мөлжигч феодалууд, гадаадын боолчлогчдын дарлал туйлдаа хүрсэн тус орны үндэсний чөлөөлөх хөдөлгөөнийг идэвхжүүлэв.
Дарлан боолчлогчдын эсрэг монголын хөдөлмөрчдийн зэвсэгт тэмцлийг монголын ард түмний үнэнч хүү, цогт эх оронч, интернационалч Дамдины Сүхбаатар болон түүний дайчин хамтран зүтгэгчид 1921 оны гуравдугаар сард үндэслэн байгуулсан ардын хувьсгалт нам манлайлжээ.
Хувьсгалын ялалтын дараагаар улс орондоо ардын засгийг тогтоосон нь эрх чөлөө, тусгаар тогтнол, дэвшлийн замыг сонгон авсан ардын хувь заяанд эргэлтийн үе болсон билээ. Энэ замаар замнахын тулд монголын бүх ард түмэн, түүний хувьсгалт намд шийдэмгий ажиллагаа, бүтээлч санаачилга, чармайлт, хүч хөрөнгийг дээд зэргээр дайчлах явдал шаардагдсан юм. Яагаад гэвэл шинэ нийгмийг амьдралын бүхий л салбар дахь туйлын хоцрогдлын нөхцөлд унагаагдсан ангийн шаргуу эсэргүүцэл, гадаадын дайсагнагч хүчний өнгөлзлөгийг даван туулж байгуулах хэрэгтэй болсон юм.

Mongolia. A land of amazing scenic and climatic contrasts. A land of stalwart, hardworking, surprisingly unpretentious and as surprisingly hospitable people. A land whose history is rooted in the hoary past. Yet a land whose noteworthiest events are of our time.
Indeed, Mongolia really began to flourish after the victorious 1921 People's Revolution, as such, one of the first responses from the then oppressed peoples of the East to the Russian proletariat's taking of power in October 1917. The ideas trumpeted abroad by the Great October Socialist Revolution awakened sooner the class awareness of Mongolia's *arat* livestock workers and spurred the national-liberation movement in a land where oppression of the toiling folk by feudal exploiters and foreign enslavers had been intensified to the utmost.
In the armed struggle against their oppressors and enslavers, Mongolia's working class was led by the People's Revolutionary Party, founded in March 1921 by that true son of the Mongolian nation and staunch patriot and internationalist, Damdiny Sukhe-Bator, and his comrades.
The power of the people that was set up in the country after the triumphant revolution marked a turn in the tide of their destiny for the *arats* who had now embarked upon the road of freedom, independence and progress. To advance along this road it was vital for the people of Mongolia and their revolutionary party to demonstrate daring innovation and creative initiative and to muster to full all their energies and resources. After all, they had to start building a new society in conditions marked

Намын анхдугаар их хурал.
Зураач Б. Равсал

The 1st Party Congress.
By B. Ravsal

Д. Сүхбаатар,
Х. Чойбалсан. 1921 он

D. Sukhe-Bator and Kh. Choibalsan in 1921

Нийслэл Хүрээг чөлөөлсөн нь. Зураач Г. Одон

The Liberation of Urga. *By G. Odon*

1921 оны долдугаар сард Уланбаатарт Монголын түр засгийн газар байрлаж байсан байшин

Residence of Mongolia's Provisional Government in Ulan Bator in July 1921

Шинэ монголыг байгуулахад 1921 оны арван нэгдүгээр сард Москвад ирсэн Д. Сүхбаатар тэргүүтэй монголын төлөөлөгчидтэй уулзахдаа В. И. Лениний өгсөн зөвлөлгөө асар их ач холбогдолтой болов. Хоцроргдсон улс орон капиталист хөгжлийн шатыг алгасан социализмд шилжих боломцооны тухай Лениний сургаалыг амьдралд хэрэгжүүлэн, Зөвлөлт Холбоот Улс, социалист нөхөрлөлийн бусад оронтой ах дүүгийн харилцаа нягт хамтын ажиллагаа, харилцан туслалцааг бүх талаар хөгжүүлэн монголын хөдөлмөрчид социалист нийгмийг амжилттай байгуулж байна. Ардын засгийн жилүүдэд буюу өөрөөр хэлбэл нэг үеийнхний амьдрах хугацааны дотор монгол орон феодализм, дундад эртний үеэс, социализмын ертөнц, орчин үеийн дэвшилд асар том үсрэлт хийлээ.

Өнөөгийн Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол орчин үеийн олон салбар бүхий эдийн засаг, цэцэглэн буй соёл, хүн амын өсөн нэмэгдэж буй аж байдал бүхий, эрчимтэй хөгжиж байгаа социалист улс юм.

by extreme backwardness in every field and yet, at the same time overcome the frenzied resistance of the ousted classes and repulse the encroachments of hostile external forces.

The advice that Vladimir Lenin gave Damdiny Sukhe-Bator and the members of the Mongolian delegation that came to Moscow in November 1921, was of inestimable significance for the shaping of the new Mongolia. Having translated into reality Lenin's teachings as to the possibility of hitherto backward countries skipping the stage of capitalism and arriving straight at socialism, and promoting in every conceivable way relations of fraternal friendship, close cooperation and mutual assistance with the Soviet Union and the other countries of the socialist community, the working people of Mongolia are successfully building a socialist society. In the years that have elapsed since the inauguration of people's power, that is within the lifetime of but one generation, if not less, Mongolia took a more than seven-league stride forward from medieval feudalism to socialism and modern progress.

Today the Mongolian People's Republic is a dynamically developing socialist state with a modern diversified economy and flourishing culture, wherein popular standards of welfare are continually rising.

Д. Сүхбаатар ажил дээрээ. Зураач Б. Равсал

D. Sukhe-Bator at His Desk. *By B. Ravsal*

Д. Сүхбаатарын ажлын өрөө. Улаанбаатар дахь Хувьсгалын музей

D. Sukhe-Bator's study. Museum of the Revolution. Ulan Bator

Арми командлагч Г. М. Штерн, БНМАУ-ын маршал Х. Чойбалсан, корпус командлагч Г. К. Жуков (зүүнээс баруун гар тийш) нар байлдаан болж буй районд. Халхын гол, 1939 он

From left to right: *Soviet Army Commander G. Shtern, Marshal of the Mongolian People's Republic Kh. Choibalsan, and Corps Commander G. Zhukov at the Khalkhin-Gol theatre of hostilities. 1939*

Монгол, зөвлөлтийн ард түмний дайчин нөхөрлөл яруу алдарт түүхтэй билээ. Ардын түр засгийн газрын хүсэлтээр тусламж үзүүлэхээр ирсэн Улаан Армийн ангиудын хамтаар Монгол ардын хувьсгалт цэрэг 1921 оны долдугаар сард Нийслэл хүрээг чөлөөлж дараа нь улс орныг цагаантны дээрэмчдээс цэвэрлэн, ардын хувьсгалын ялалтыг хангав.
Монголын ард түмний хувьсгалт байлдан ололтыг хамгаалахад 1936 онд БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан харилцан туслах тухай протокол үнэлж баршгүй ач холбогдолтой билээ. 1939 онд Японы милитаристууд БНМАУ руу Халхын голын районоор довтлоход монголын цэрэг, өөрийн үнэнч анд нөхөр зөвлөлтийн цэрэгтэй мөр зэрэгцэн түрэмгийлэгчдэд үхлийн цохилт өгөв.
Дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд Монголын Ардын Армийн анги нэгтгэлүүд Зөвлөлтийн Армийн хамт Японы милитаризмыг бут ниргэж, зүүн хойт хятадын ард түмнийг чөлөөлөхөд оролцов. Өөрийн интернационалч үүрэгтээ үнэнч зөвлөлтийн цэрэг монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолд аюул занал учрах бүрийд найрамдлын гараа сунгаж тусламж үзүүлж ирсэн билээ.
Үүгээрээ тэд монголын ард түмний ах дүүгийн хайр талархлыг хүлээсэн юм.

Зэвсэг нэгт нөхөд

Comrades-in-arms

Гагнагдан тогтсон
Монгол-Зөвлөлтийн
бат найрамдал
Галзуурсан дайсныг
Халхын голд
хэмх ниргэсэн

Гайхамшигт ялалтын
сайхан алдар
үргэлж цууриатна.
Гарамгай дайчдын
баатар үйлс
үүрд дурсагдана.

Д. Тарва

Glory eternal to Khalkhin-Gol's heroes!
Glory eternal to the victories won!
Ever since Russian Mongol's friend and brother
Stronger than us in the wide world are none!

D. Tarva

The annals of the comradeship-in-arms of the Mongolian and Soviet peoples contain many a glorious page. In July 1921, in combined operations with Red Army units despatched at the request of the Provisional People's Government of Mongolia, the Mongolian People's Revolutionary Force liberated the capital, Urgu, and subsequently expelled the White-Guard bands from the country, thus ensuring the full victory of the People's Revolution.
The Mutual Assistance Pact that the Mongolian People's Republic and the Soviet Union concluded in 1936 was of priceless importance for safeguarding the revolutionary gains of the people of Mongolia.
When, in 1939, the Japanese militarists attacked the Mongolian People's Republic in the River Khalkhin-Gol sector, the Mongolian army, fighting shoulder to shoulder with its true friends, the Soviet soldiers, inflicted a devastating defeat upon the aggressor.
During the Second World War units and formations of the Mongolian People's Army participated, together with the Soviet Armed Forces, in the effort to rout Japanese militarism and liberate the peoples of North-East China.
Loyal to their internationalist duty, the Soviet soldiers have always extended a hand of friendship and help to the people of Mongolia whenever their freedom and independence have been threatened. They have thereby earned the Mongolian people's fraternal love and gratitude.



ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. В. Андропов МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалтай уулзаж ярилцав. Москва, 1982 оны 12-р сарын 24

Yuri Andropov, General Secretary of the CPSU Central Committee, meets Yumzhagiin Tsedenbal, General Secretary of the Central Committee of the Mongolian People's Revolutionary Party and President of the Presidium of the Great People's Khural of the Mongolian People's Republic. Moscow. December 24, 1982

ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. В. Андропов МАХН-ын Төв Хорооны Ерөнхийн нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалтай уулзаж ярилцахдаа хоёр нам, Зөвлөлт Холбоот Улс, БНМАУ эвдэршгүй найрамдал, сэтгэл харамгүй харилцан туслах явдал, үзэл санааны бат нэгдлийн уламжлалд үндэслэсэн зөвлөлт, монголын ард түмний ах дүүгийн харилцааг цаашид хөгжүүлэн гүнзгийрүүлэх шийдвэр төгс байгаагаа илэрхийлэв.

When Yuri Andropov, General Secretary of the CPSU Central Committee, met Yumzhagiin Tsedenbal, General Secretary of the MPRP Central Committee and President of the Presidium of the Great People's Khural of the Mongolian People's Republic, they voiced the resolve of the two Parties and countries to further promote and deepen the relations between the peoples of the Soviet Union and the Mongolian People's Republic, relations that are based on traditions of unbreakable friendship, disinterested mutual assistance and firm ideological unity.

МАХН-ын XVIII их хурал дээр. Улаанбаатар, 1981 оны тавдугаар сар

At the 18th Congress of the Mongolian People's Revolutionary Party. Ulan Bator. May, 1981



Удам цэлгэр оронд минь
Улаан наран мөнхжөөстэй
Ундрах хөдөлмөрийн цууриа
Уулгүй талд ч хангинаастай
Тал арвин нутаг минь
Тариан тэнгэс долгилоостой
Таван хошуу мал минь
Тавлаг тэнүүн үржээстэй.

Л. Түдэв

In land of mine, this land, far spreading,
Road of peaceful work e'er treading,
On snow-capped peaks the rising sun
In red has pattern handsome spun...

For all is mine: the orchards, gardens,
The ways and paths that winds have hardened,
Of sheep the flocks, of horses herds,
The spreading steppes, the beasts, the birds.

L. Tudev



ШИНЭ ХӨДӨӨ
THE NEW SOCIALIST VILLAGE

Үзэсгэлэнт байгалийн дунд бэлчээрлэгч мал сүрэг, морьтон ард... Энэ бол нүүдлийн мал аж ахуй эртнээс авахуулаад бараг бүх хүн амын нь аж төрөл болж байсан өнгөрсөн үед монголын өвөрмөц дүр зураг болж байлаа. Гэхдээ малчин монголчуудын аж амьдрал харах өнгөндөө санагдах мэт тийм амар жимэр байсангүй. Тэд хатуу ширүүн байгалийн гамшиг, хар шар харгис феодалуудын дарлал, харь газрын капиталын нүнжиггүй мөлжлөгийг амсаж байлаа.
Монголын тариачид шинэ, социалист байгуулал, аж ахуйн хамтын хэлбэрийн үед шинэ хүч чадлыг олсон юм. Хувийн аж ахуйтны сайн дураараа хоршооллох хөдөлгөөн тавиад оны сүүлчээр амжилттай болж, хөдөөд социалист үйлдвэрлэлийн харилцааны ялалтыг хангасан юм.
Орчин үеийн монголын хөдөө аж ахуй олон салбартай болжээ. Түүний уламжлалт, голлох салбар нь мал аж ахуй бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дөрөвний гурвыг үйлдвэрлэдэг юм.
Сүүлийн үед Монгол орны хувьд шинэ салбар болох газар тариалан эрчимтэй хөгжиж байна. Ардууд тариа тарьж, үр тарианы үндсэн хэрэгцээгээ өөрсдийнхөө бүтээгдэхүүнээр хангаж хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж байна. Тус оронд атар газар эзэмших явдал үргэлжилсээр байна.
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд гарсан чанарын гүн их өөрчлөлт хөдөөгийн хөдөлмөрчдийн аж амьдралыг өөрчилжээ. Тэдний соёлын түвшин дээшилж материаллаг аж амьдрал сайжирсан байна. Үзэсгэлэнт эсгий гэрүүдээс бүрдсэн хот айлуудын зэрэгцээ тохилог барилга байшин, сургууль, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд саатуулах газар, эмнэлэг, соёл, худалдаа, ахуйн үйлчилгээний газар бүхий орчин цагийн шинэ суурингууд богино хугацаанд сүндэрлэн боссоор байна.
Хамтын хөдөлмөрийн хүчирхэг хүч хийгээд шинжлэх ухаан, практикийн ололтод түшиглэсэн мэдлэг туршлага нь байгалийн олон аашийг амжилттай даван туулах, аж ахуйгаа зөв, ашигтай хөтлөх үйл хэрэгт хөдөөгийн монгол хүний өнөөгийн зэвсэг болжээ.
Бэлчээрлэж яваа тарган мал, тариалангийн талбай дахь хүчирхэг трактор, комбайн, үржил шимтэй цэцэрлэг, үр жимс, хүнсний ногоо үржүүлгийн газар, орчин үеийн өндөр механикжсан иж бүрэн барилга байгууламж, шинэчлэгдэн залуужсан хот айл, хөдөөний шинэ суурин энэ бүхэн бол монголын хөдөөгийн өнөөгийн дүр зураг юм.

An *arat* on horseback herding flocks against the backdrop of picturesque scenery. Such in the past was the picture one had of Mongolia, whose nomad pastoral economy provided from times immemorial the means of subsistence for the overwhelming majority of its population. Yet the life of the Mongolian herder was not as serene and unruffled as one might have thought. He constantly had to battle with the wild elements and was cruelly oppressed by the local feudal lords, the parasitic, reactionary clergy and foreign capitalists.
The *arat* fully squared his shoulders only when the new socialist system came into being, and collective farming was introduced. The successful completion, towards the close of the 1950s, of the voluntary association of private cattlefarmers into cooperatives ensured the victory of socialist relations of production in the countryside.
Mongolia's agriculture is today a highly diversified branch of the national economy. In the lead here is the traditional line of stockbreeding, which accounts for three-fourths of agriculture's total output.
However, recent years have witnessed the spread of such a new line as tillage of the land, with the *arat* peasantry cultivating cereals to thus meet their basic grain requirements, and also growing vegetables, fruit, berries, etc. The reclamation of the virgin lands programme continues in the country.
The profound changes to be observed in the levels of agricultural production have also changed rural life. Material and cultural standards have risen. Today one sees mushrooming alongside of encampments of highly decorative felt *yurts*, whole settlements of well-appointed dwellings with all the necessary cultural, public, health and educational services and amenities.
Today knowledge and knowhow, augmented by the herculean power of work in common and achievements in science and practice, enable the Mongolian *arat* to rationally and profitably operate and successfully withstand the vagaries of nature.
The socialist village of today's Mongolia presents a picture of herds of sleek cows and flocks of woolly sheep, rolling fields worked by tractor and harvester-combine, blossoming orchards, and sophisticated, highly-mechanized complexes, while the *yurt* encampments that are neighbours of the new agrotowns are now more festive, younger.





Талын өнгө
Ногоон, цэнхэр, шаргал, улаавтар
Адууны зүс
Цагаан, хар, хүрэн, хээр алаглана.

П. Бадарч

In steppes flowers bloom in diverse hues,
by sunlight colours blurred.
As different, too — bay, black and white —
are the horses in a herd.

P. Badarch

Монголчууд зочин гийчиддээ мөнгөн аягатай сүү хадагтай барьж, эрүүл энх, сайн сайхны ерөөл дэвшүүлдэг

In Mongolia it is the custom to welcome guests with bowls of milk or koumyss, *thereby to wish them good health and prosperity*



Урсаа горхи хоолой мэдэн шулганаж
Ургаа модод нэвсийж ногоорон суглийнэ.
Сувдан одод огторгуй дундаа анивалзаж
Сугадалцсан хоёр борхон зүрхсээ гижигдэнэ.

Л. Түдэв

O' er world below hand pearly heavens high.
Trees are wrapped in silence. But one small cry
From stream rends the hush, "Come what may, come what may!
Two loving hearts beat in unison today!"

L. Tudev







«Говь цөлийн хөлөг» маань эдүгээ хот, хөдөөгийн хүмүүст хичнээн ачтай тустай

In Mongolia the "ship of the desert" faithfully serves the farmer

Манантах алс тэртээ дүнхийн бараантах байгальд
Манхан талын заан-тэмээн сүрэг зурайна...

Л. Түдэв

Etched against horizon, stand camels in the distance;
And seem they part of scenery, of Nature's system.

L. Tudev



Нарийн өвс ургасан малын сайхан бэлчээртэй
Нааш цааш сүлжих тэнэгэр сайхан нутагтай...

Д. Нацагдорж

Have we pastures and meadows where all the year round
Grazing abundant for herd and flock may be found.

D. Natsagdorzh

Ногооны аж ахуй бол БНМАУ-ын социалист хөдөө аж ахуйн ирээдүйтэй салбар мөн. Хотууд, аж үйлдвэрийн төвүүдийг тойруулан ногооны аж ахуй эрхэлдэг сангийн аж ахуйнууд байгуулж, хүлэмжийн талбайг өргөтгөж байна

The vegetable-growing represents a highly promising branch of Mongolia's socialist agriculture. Many vegetable-growing state farms, that are extending hothouse cultivation, have been organized in the immediate vicinity of the country's cities, towns and industrial centres



«Улаан Толгойн» сангийн аж ахуйн мал аж ахуйн нэг механикжсан цогцолбор дээр

In one of the premises of the highly-mechanized livestock complex of the Ulan Tolgoi State Farm

Монголын хөдөөгийн хөдөлмөрчид, тэдэнд туслахаар ирсэн зөвлөлтийн мэргэжилтнүүдэд нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг улам дээшлүүлэхийг хангах гэсэн нэгэн зорилго байдаг

Mongolia's farmers share one common desire with the Soviet specialists who assist them — this is to raise still higher the levels of performance in the socially-owned sector of production



Тохилог орон сууц, соёл, эрүүлийг хамгаалах, ахуйн үйлчилгээ, сургууль, хүүхдийн ясли, цэцэрлэгийн орчин үеийн барилга бол өнөөгийн монголын хөдөөгийн дүр зураг болой

The Mongolian village today is a modern rural community of well-appointed dwellings with all the essential cultural, health and public services and amenities, and also schools, kindergartens and crèches

Цэн хунгийн далиаг цуцаанхан сульдаадаг тал минь
Цээлхэн дууны хөгийг исгэрэнхэн бүжих тариалан
Цэлгэр уужим биеийг чинь чимэглэнхэн найгаж байна.

Л. Тудэв

Like gold that in the sunshine glorious glistens,
The gleaming rolling fields of ripened wheat...
Await, obedient to man's volition.

L. Tudev

Аварга их алхаагаараа
Эрин цагийг товчилж
Амьдрал шимтэн урамшиж
Эгнэшгүй мөрөөдлийг ч хэрэгжүүлэг
Эх орон минь, Монгол минь
Энгүй уудам нутаг минь
Үндран үндрах бүтээн байгуулалтад
Улам, улам өнгөжин жавхаажина...

Д. Сэнгээ

O, land of mine, seven-league strides you take
As the months and the years roll by,
With daring inspiration undertake
Our cherished dreams to gratify.
Mongolia, forever are you young —
To which grand programmes testify.

D. Sengeneh





ҮЙЛДВЭРИЙН АЛХАА
THE ONWARD MARCH OF INDUSTRY

Өнөөгийн Монгол орон зөвхөн мал аж ахуй, газар тариалан эрчимтэй хөгжиж байгаа улс төдийгүй жил ирэх тутам газрын зураг дээр нь улам улам олон үйлдвэрийн газар тодрон байгаа улс юм. Тэдгээрийн тоонд юуны өмнө монгол-зөвлөлтийн хамтран байгуулсан уулын баяжуулах «Эрдэнэт» комбинатыг оруулах хэрэгтэй. Эрдэнэсийн сан Эрдэнэтийн овоонд алтан мөнгөн завьяа бүхий асар том зэс тогоо булаастай ажээ. Тэр тогоог олж завьяаны нь оюу, номин тагийг авахад хүн ард шинэ аз жаргалтай амьдралаар амьдрах болно... Монгол домогт ингэж өгүүлсэн байна. Эрин зуун улиран өнгөрч эрх чөлөөт монголын ард түмэн найз нөхдийнхөө хамт домгийг үнэн болгов. Эрдэнэтийн овоонд зэс, молибдений асар том орд олдсон бөгөөд Ази тивд хамгийн том үйлдвэр барьж байгуулав. Түүнээс холгүй үзэсгэлэнт хот сүндэрлэн босов. «Эрдэнэт» интернационалч үзлийн сургууль, үндэсний боловсон хүчнийг бэлтгэх уурхай болов. Энд монгол-зөвлөлтийн олон улсын экипаж, бригад, «Найрамдал-Дружба» гэдэг ээлж төрөн гарсан бөгөөд одоо ийм экипаж, бригад ээлж тус улс орон даяар тархжээ. Аж үйлдвэрийн дээд зэргийн ашигтай бүтцийг байгуулах зорилгын үүднээс БНМАУ-д дулаан-эрчим хүч, уул уурхай, барилгын үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж байна. Үүний зэрэгцээ монгол орны хувьд уламжлалт салбар болох хөнгөн, хүнсний үйлдвэрийг хөгжүүлж байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүдийг шинэтгэн ажиллуулж байна. Арьс ширний үйлдвэр, нэхий, нэхий эдлэлийн үйлдвэр, хивсний үйлдвэр, ноосны үйлдвэрийн бүтээгдэхүүн дотоод, гадаадад туйлын их хэрэгцээтэй бараа юм. Монголын нэхий дээл, хивс, бусад олон бараа олон улсын яармаг, үзэсгэлэнгийн дээд шагнал удаа дараа хүртсэн юм.

Түүхэн богино хугацаанд Монголд эдүгээ монголын нийгмийн тэргүүлэх хүч болсон үндэсний ажилчин анги үүсэж бүрэлдсэн юм. Түүний эгнээ сүүлийн хорин жилд хоёр дахин нэмэгджээ. Одоо улс орны үйлдвэрийн цех, шинэ барилга байгууламж дээр ахмадуудын хамт монголын техникийн сэхээтэн, мэргэжилтэй ажилчдын залуу үе ажиллаж байна. Тэдний олонхи нь ах дүү социалист орнуудад мэргэжил эзэмшжээ. Монголын ард түмэнд социалист байгуулалтад нь интернационалч тусламж үзүүлж байгаа ЗХУ, Болгар, Унгар, БНАГУ, Польш, Чехословак болон ах дүү бусад орны мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байгаа нь монголын хөвгүүд охид шинэ мэргэжил өргөнөөр эзэмших, монголын ажилчид, техникийн ажилтан инженерүүд мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд идэвхтэй үр нөлөө үзүүлж байна.

Mongolia today is to be complimented not only upon its fast-developing agriculture. More and more industrial capacities are activated with every year. Leading the list is the joint Soviet-Mongolian *Erdenet* Ore-Dressing Complex.

According to a time-hallowed legend, concealed in Erdenetiyn-Obo, the Mountain of Treasures, is a giant copper cauldron with jars of silver and gold. When people will at last find it and remove from the jars their lids of turquoise and lapis lazuli, they will live happily ever after. With the passage of time the people of free Mongolia have with their friends made this tale of fancy come true. When discovered within this mountain were large deposits of copper and molybdenum, built at its foot was Asia's biggest industrial enterprise and in its vicinity a handsome, well-appointed township of the same name.

Erdenet is a school inculcating the spirit of internationalism, a centre training national pools of manpower in diverse trades. There were first organized here the joint Soviet-Mongolian teams and the *Friendship-Nairamdal* shifts, that subsequently spread to other of Mongolia's building sites and enterprises.

To secure an optimal infrastructure in Mongolia's industry, efforts are being made to promote a much faster tempo of advance in the fuel and power, and mining industries. New capacities for the processing of livestock produce have been put into operation, while existing capacities have been modernized. Indeed, the range of items that are turned out by the country's leather, sheepskin, carpet and worsted-wool factories command a ready sale both at home and abroad. Mongolia's working class, today the leading force of its society, emerged over what is historically speaking a brief span on time. In the past twenty years its numerical strength has doubled. Working alongside of labour veterans at the country's industrial enterprises and building sites are competently trained workers and engineers of the younger generation, many of whom were appropriately educated in the other fraternal socialist countries. Further, work in cooperation with specialists from the Soviet Union, Bulgaria, Czechoslovakia, Hungary, the GDR, Poland and other socialist countries, who are rendering the people of Mongolia true internationalist assistance to build socialism, enables representatives of the younger generation of the working class to learn new trades and raise their skills.

Зэс-молибдений уулын баяжуулах «Эрдэнэт» комбинат бол монгол-зөвлөлтийн ах дүүгийн найрамдлын үр юм. Энд зөвлөлтөд үйлдвэрлэсэн хүчирхэг техник, тоног төхөөрөмжийг ашиглаж байна

The Erdenet Copper and Molybdenum Ore-Dressing Complex, which is outfitted with Soviet-made powerful, sophisticated equipment, well attests to the fruitful results of Mongolian-Soviet brotherhood

«Эрдэнэт» комбинатын баяжуулах фабрикийн гол байранд

In the central building of the ore-dressing factory of the Erdenet *Complex*



Хүчирхэг, их даацтай ачаагаа өөрөө буулгагч машин жолоодох нь «Эрдэнэт»-ийн нэр хүндтэй мэргэжлийн нэг болжээ

One of the most prestigious callings at the Erdenet Complex is to be driver of a heavy-duty tip-up lorry

«Эрдэнэт»-ийн уламжлал... Энэ ухагдахуунд Эрдэнэтийнхэн хамтран ажиллах, туршлагаа харамгүй солилцох, бие биеэсээ сурах, чөлөөт цагаа хөгжөөнтэй өнгөрөөх чадамжийг нэмэрлэж байна

The personnel of the Erdenet Complex have already established many fine traditions, which they understand as pulling in harness, generously sharing knowhow, learning from one another, spending leisure time and holidays together



Эрдэнэт уулаас холгүй үзэсгэлэнт Эрдэнэт хот сүндэрлэн босов. Түүний ерөнхий зураг төслийг зөвлөлт, монголын мэргэжилтнүүд боловсруулжээ

The Master Plan for the construction of the handsome town of Erdenet, which has mushroomed in the neighbourhood of the Mountain of Treasures, is the joint brainchild of Soviet and Mongolian specialists




СЛА
КПСС МАХН



Тус улсын төмөр замын тээвэр нь автомашин, агаарын тээврийн зэрэгцээ улс ардын аж ахуйд асар их үүрэг гүйцэтгэж байна. Ган замын гол шугам монголын газар нутгийн хойт зүгээс өмнө зүгийг хүртэл нэвт зурайн, үйлдвэрийн шинэ шинэ төвүүд рүү салаалан оддог

Along with the airways and motor-roads, the republic's railways on a large scale contribute to the accomplishment of economic objectives of vast significance. The railway crosses Mongolia from North to South and spurs strike off to new industrial centres

Монголын үйлдвэрийн том төв Дарханыг интернационалч найрамдлын хот гэж зүй ёсоор нэрлэдэг юм. Эл хотыг ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын туслалцаатайгаар барьсан юм

Darkhan, Mongolia's largest industrial centre, is rightly dubbed a city of international friendship, as it was built with the cooperation of the brother-countries of the Council of Mutual Economic Assistance



Монголын барилгын шинэ шинэ объектад цемент улам их хэрэгтэй. Түүнийг Дархан дахь цементийн төв үйлдвэр үйлдвэрлэж байна

With increasing supplies of cement required for various construction jobs, output is rising at the cement mills in Darkhan





Өндөр хүчдэлийн цахилгаан шугам сүлжээ, цахилгааны болон дулааны станцын барилгууд өнөөгийн монголын дүр зургийн өвөрмөц онцлог мөн

High-tension electric transmission lines and power stations are today a characteristic feature of Mongolia's scenery





БНМАУ-ын хүнсний үйлдвэр сүүлийн жилүүдэд орчин үеийн шинэ үйлдвэрүүдээр баяжив. Мах, махан бүтээгдэхүүн нь монголын экспортын чухал бүтээгдэхүүний нэг мөн

Meat and meat products comprise a key branch of Mongolia's export trade, contributed thereto by its food industry which in recent years has been augmented with many new sophisticated capacities



Монголчууд өнө эртнээс хивс нэхэж иржээ. Эдүгээ энэ нь үйлдвэр болон хөгжив. Монголын уран гартангуудын урласан хивс худалдан авагчдын байнгын эрэлт хүсэлттэй бараа бөгөөд олон улсын яармагийн хэд хэдэн дээд шагнал хүртжээ

Mongolia's time-hallowed craft of carpet-weaving has currently been placed on a more modern industrial footing. Mongolian rugs and carpets, which have merited top honours at international fairs, are in great and invariable demand

Малын арьс, нэхийгээр гоёмсог нэхий, илэг, савхин дээл, бусад хувцас, өргөн хэрэгцээний олон төрлийн том жижиг бараа хийж байна. Тус оронд бөс барааны үйлдвэрлэл, жинхэнэ ноос, тэмээ, ямааны ноолуураар хийдэг хувцасны үйлдвэрлэл нэмэгдэж байна

The output and range of superior sheepskins, well-crafted leather and fur coats, and various accessories, as well as of cloth and other fabric and garments of natural wool, angora and camelhair, are growing all the time

Сая хүний уран гарын чадлаар бүтэж буй
Сайхан орды туурга бүрээс туяа цацарна
Уулаас талыг хүртэл хөдөлмөр оргилсон
Умраас өмнийг хүртэл хөгжил цогцолсон
Зүйрлэшгүй уужим дархны газар — эх орон
Зүйдэлгүй тэнгэрийн дор хоёр дахь наран билээ

Л. Түдэв

The stirrings of our hearts and minds are pure as crystal;
In the whole wide world no ideas more beneficial.
Beneath heavens unmarred by thunder cloud,
My land is like a busy buzzing beehive
Where we with industry work and happy live;
Land of sunshine, of which we're ever proud.

L. Tudev





САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ !
FOR THE GOOD OF ALL AND EVERYONE

Нийгмийн гарал, үндэс угсаа, хүйс харгалзалгүй нийгмийн бүх гишүүдийн жинхэнэ тэгш эрхийг хангах бодлогыг монголын ардын төр тууштай хэрэгжүүлж байна. МАХН-аа хүрээлэн нягтарсан ажилчин анги, хоршоологосон ард, сэхээтнүүд монголын нийгмийн бат бэх, эвдэршгүй нэгдлийг хангаж байна.
Ардын монгол улсын нийгмийн лут их ололтын нэг нь эмэгтэйчүүдэд эрх чөлөө олгож эрэгтэйчүүдийн нэгэн адил жинхэнэ ёсоор эрх тэгш болгосон явдал юм. Эрх мэдэлгүй, бичиг үсэггүй байсан монгол эмэгтэй одоо шинэ нийгмийн идэвхтэй байгуулагч болжээ. Эмэгтэйчүүд эдүгээ багш, эмч нарын дийлэнх хувийг эзэлж шинжлэх ухаан, урлаг эрхэлж, БНМАУ-ын Ардын Их Хурлын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын депутатаар сонгогдож байна. Үндсэн хуулиар батлагдсан хөдөлмөрлөх эрх, эмчлүүлэн сувилуулах эрх, нийгмийн тусламж авах, амрах эрх гэх мэт ойлголтын тодорхой утга агуулгыг монголын хөдөлмөрчид социалист нийгмийн үед л сая бүрэн дүүрэн ухаарч, эл эрхийг эдэлсэн юм.
Монгол Ардын Хувьсгалт Нам, БНМАУ-ын засгийн газар нийгмийн лут их программыг хэрэгжүүлэн хүн амын орон сууцны нөхцөл, ахуйн үйлчилгээг сайжруулахад их анхаарч байна.
Монгол айл олон хүүхэдтэй байдаг нь уламжлалт ёс. Гэвч хувьсгалын өмнөх Монголд хүн ам чухамдаа өсөөгүй юм. Тэр ч байтугай нийгмийн хоцрогдол, өвчин эмгэг, шашны нөлөө зэргээс монгол үндэстэн сөнөх ноцтой аюулд учирч байлаа. Иймээс хүн амын эрүүл мэндийн талаар явуулах ажлыг ардын засаг тогтсон анхны өдрүүдээс эхлэн төрийнхөө бодлого болгожээ. Ардын засгийн өнгөрсөн жаран жилийн дотор тус орны хүн ам хоёр гаруй дахин нэмэгдэж, хүмүүсийн дундаж нас үлэмж өсөв.
«Үр хүүхэд бол эрхэм дээд баялаг» гэдэг монгол цэцэн үг байдаг, иймч учраас идэр залуу үеийг эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, төгс хөгжилтэй өсгөхийн төлөө бололцоотой бүхнийг БНМАУ-д ч хийж байна. Иймээс эх, нялхсыг хамгаалах талаар онцгой их анхаарал тавьж байна.
Түүнчлэн социалист Монгол улсын энэрэнгүй үзэл санаа нь хөдөлмөрчдийн нийгмийн хангамж, амралт, сувилалт, эрүүлжүүлэх арга хэмжээ болон биеийн тамир, спортод зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээ улам өсөн нэмэгдэж байгаагаар илэрч байна.

The people's state of Mongolia consistently implements a policy of real equality for all citizens regardless of national and social origin or sex. Rallied around the Mongolian People's Revolutionary Party, the working class, *arat* peasantry and labouring intelligentsia comprise a firmly-knit, unbreakably united society.
The emancipation of the country's womenfolk, their establishment on a truly equal footing with the opposite sex, represents one of People's Mongolia's major social gains. Downtrodden and illiterate in the past, they are actively involved today in the building of the new society. They comprise most of the teaching and medical professions, engage in science and art; many have been elected deputy to the Great People's Khural (parliament) of the Mongolian People's Republic, and to bodies of local government.
The concrete meaning embodied in such concepts as the right to work, the right to health protection, the right to social security, and the right to leisure, rights that are ensured by the country's Constitution, have been fully understood and realized by the working people only under socialism.
In the effort to implement its wide-ranging social programme, Mongolia's Revolutionary Party and Government attach priority to better housing and public services and amenities.
By tradition the Mongolian family is generally a large one. However, before the Revolution, the natural growth of the population was virtually down to zero. On the contrary, social backwardness, epidemics coupled with the lack of health services and, finally, the large proportion of celibate monks that religion dictated, threatened national degeneration. No wonder that from the very outset, the new People's Government made health care for the population a dominant policy of state. In the upshot of this effort the population has more than doubled over the elapsed sixty years of people's power, while the average life expectancy has markedly lengthened.
According to a sage popular maxim in Mongolia children comprise the most precious of treasures. True enough, in the Mongolian People's Republic everything conceivable is done to bring up a healthy, well-educated and harmoniously developed younger generation. Special concern, naturally, is lavished on mother and child care.
The humanitarian character of the Mongolian socialist state is expressed likewise in the growing budget earmarked for social security and maintenance, leisure facilities, the promotion of health, and sport.

Улаанбаатар, Дархан хотод байшин үйлдвэрлэх том комбинат барьсан нь орон сууц барих ажлыг улс орон даяар урьд өмнө байгаагүй их эрчимтэйгээр өрнүүлэх боломжтой болов. Хүн ам, улс ардын аж ахуйг цэвэр усаар хангах ажлыг тусгай алба гүйцэтгэдэг

Thanks to the large prefabbed housing plants launched in Ulan Bator and Darkhan, housing is going up at hitherto unprecedented pace. Meanwhile a special management lays on pure water both for the population's needs and for industrial purposes



Монголын нийслэлийн барилгууд улам л өндөршин сүндэрлэх болов

New high-rise buildings in Mongolia's capital

Улаанбаатар дахь Хуримын ордон

At Ulan Bator's Wedding Palace

Хүн зоны аз жаргалын өнгөлөг цэцэгс
Хүүхдүүд тоглож байна
Амьдралын сайханд баясах эд нар маань
Алс хэтийн маань мөрөөдөл биш гэж үү!

Ш. Дулмаа

There they play,
Take delight in gladly living;
Blossoms bright, for which thanks are giving
And fulfilment of our dreams be wishing.

Sh. Dulmaa

Монголын хөдөлмөрчдийн эрүүл энхийн манаанд эрдэмтэд, нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн албаны ажилтны олон тооны отряд зогсож байна

A veritable legion of scientists, doctors and well-trained medical personnel stand guard over the nation's health







Монголын хөдөлмөрчдөд зориулж амралт, сувилал, рашаан амралт олныг барьж байгуулсан юм

In Mongolia the country's network of health and holiday homes caters to its working folk



МОНГОЛИЯ
MONGOLIE

Монголын тамирчдад Москвад болсон XXII олимпийн тоглолт хэзээд үл мартагдана...

The Games of the 22nd Olympiad in Moscow made an indelible impression on Mongolia's athletes



Биеийн тамир, спорт монголын залуучуудын байнгын дагуул болжээ. БНМАУ-ын тамирчид олон улсын тэмцээн, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, олимпийн тоглолтуудад идэвхтэй оролцдог юм

Mongolia's young people cannot be imagined without sport and physical culture. National sport is well represented at Olympics, world championships and international competitions



Монголд ирдэг жуулчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Тус орны үзэсгэлэнт нутгуудад байрласан олон тооны жуулчдын бааз тэдэнд үйлчилдэг юм.
Төв аймаг дахь жуулчдын бааз

The annually increasing tourist influx is accommodated at the country's many tourist centres located in top beauty spots.
Tourist complex in the Central Aimak

Олон улсын жуулчдын зуслан-Хужирт олонд алдартай. Түүний ойролцоо рашаан ундарга, булаг, тус орны түүхийн дурсгалт зүйлс элбэг байдаг

The Khuzhirt International Tourist Camp is well known; no wonder as next door are sites of historical interest and medicinal springs



...Ахуй нутгийн минь уулс
Алсаас сүндэрлэх оргилыг нь ороож
Аянга нижигнэн, аадар балбавч
Алтан наран дахиад мишээхэд
Аюул бэрхийг үзээгүй мэт тайван...
Алаггүй түмэн үрсийн чинь нэг би
Араар сүганд чинь төрсөндөө хүсэх нь:
Аавыгаа дуурайсан үр адил би
Нутгийнхаа уулс шиг явахсан.

П. Пүрэвсүрэн

Crags and hills serene of my native land,
Much in your time you have had to withstand —
Thunder and lightning, deluge, snow and hail,
Warm gentle sunshine, zephyr, storm and gale.
Yet happy am I to loudly declare
That I was born here, in this land so fair;
And after father always repeat,
"O mountains of mine, to heart strength bequeathe."

P. Purevsuren









Өсөхөөс сурсан үндэсний хэл, орхиж болшгүй соёл мөн
Үхтэл орших төрөлх нутаг, салж болшгүй орон мөн.
Хувьтай энэ орондоо хувьсгалт улсаа мандуулж
Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяа байгуулъя.

Д. Нацагдорж

The strains of songs I know; the language that speak;
This land of mine I love, its stately snow-swept peaks.
Everywhere I look I see a day dawn new;
My country! For your sake I live and dare and do!

D. Natsagdorzh

ЭРДЭМ, СОЁЛЫН ОРГИЛ ӨӨД
TO SUMMITS OF LEARNING AND CULTURE

Хувьсгалын өмнөх феодал-колонийн Монгол нь соёлын талаар дэлхийд хамгийн хоцрогдсон орны нэг байлаа. Одоо үед тус улсад ерөнхий боловсрол, техник-мэргэжлийн сургууль, техникум өргөн олноор байгуулагдаж, долоон дээд сургууль ажиллаж байна. Сургуулийн насны хүүхдийг заавал нийтээр нь бүрэн биш дунд боловсролтой болгох шатандаа шилжлээ. Ерөнхий, тусгай, дээд боловсролын сургуулийн систем бий болж монголчуудын боловсролын түвшин дээшилсэн нь эх орны шинжлэх ухааныг хөгжүүлэх найдвартай суурь болж байна. Одоо БНМАУ-ын ШУА-ийн бүрэлдэхүүнд орчин үеийн мэдлэгийн бүх салбарт шинжилгээний ажил эрхэлсэн хорь шахам эрдэм-шинжилгээний институт байна.

Монголын эрдэмтэд ах дүү социалист орнуудын, юуны өмнө Зөвлөлт Холбоот Улсын эрдэмтэдтэй үр ашигтай хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна. Нийгмийн шинжлэх ухаан, геологи, биологи, гидрологи, газарзүй, палеонтологи гэх мэт шинжлэх ухааны салбарт ч иймхамтын ажиллагаа хөгжиж байгаа юм. БНМАУ-ын нутаг дээр ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын бүрэлдэхүүнтэй Олон улсын геологийн экспедиц амжилттай ажиллаж байна. «Союз-39» хөлөг дээр хийсэн зөвлөлт-монголын сансрын нислэг монголын шинжлэх ухааны гайхамшигт амжилт байлаа. БНМАУ, ЗСБНХУ-ын эрдэмтэд, инженер, сансрын нисэгчид шинжлэх ухаан, практикийн их ач холбогдолтой өргөн программыг биелүүлсэн юм. Монголын эрдэмтэд Дубна дахь цөмийн шинжилгээний Нэгдсэн институт, бусад олон улсын байгууллага ба төвүүдэд амжилттай ажиллаж байна.

Монгол бол эртний өвөрмөц соёлтой орон. Гэсэн ч нийгмийнхээ оюун санааны амьдралд ард олон нь одоо шиг ингэж нийтээрээ идэвхтэй оролцож байсан нь түүний олон зуун жилийн түүхэнд хэзээ ч байгаагүй юм. Тус оронд соёл-гэгээрлийн байгууллага, номын сан, радио, телевиз, сонин сэтгүүл, ном хэвлэл түйлын их хөгжсөний ачаар ард олонд тийм болоцоо олджээ. Хүн амын бүх давхаргын уран сайхны бүтээлч ажиллагаа шинэ, өргөн шатанд гарчээ. Ардын авьяастнуудыг шалгаруулахаар тус орон даяар үе үе зохиож байгаа үзлэг, фестиваль нийт ард түмний урлагийн баяр болон хувирч байна.

БНМАУ-д утга зохиол, мэргэшлийн урлаг жинхэнэ ултай цэцэглэн мандаж байна. Эдүгээ монголын зохиолчдын зохиолыг Монголд төдийгүй гадаадад ч ихэд сонирхон уншдаг болжээ. Монголын соёлын эрдэнэсийн санг уран зураг, хөгжим, театр, киноны гойд сайхан бүтээлүүд баяжуулж байна. Монголын өвөрмөц урлаг дэлхийн олон оронд зүй ёсоор нэр алдрыг олжээ.

From the angle of cultural levels pre-revolutionary feudal colonial Mongolia was one of the world's most backward countries.

Today the republic boasts a comprehensive network of general-educational and vocational schools, technical secondary educational establishments, and seven university-level colleges. The programme of universal compulsory eight-year schooling for all children of school age is currently in the transitional stage. As is only natural the operating systems of secondary and higher schooling, along with the generally rising educational levels provide a fine foundation for the advance of science. Today the Mongolian People's Republic's Academy of Sciences has actively working within its framework close onto a score of research establishments conducting scientific investigations in all the basic fields of modern knowledge.

Mongolia's scientists maintain fruitful links of cooperation with their opposite numbers in the fraternal socialist countries, firstly the Soviet Union, in such spheres as the social disciplines, geology, biology, hydrology, geography and paleontology — to mention only several. Thus specialists from member-states of the Council for Mutual Economic Assistance are participating in an international geological expedition that is doing successful work on Mongolian territory.

A great achievement for Mongolian scientists was the joint Soviet-Mongolian space experiment aboard the *Soyuz 39* spacecraft. The scientists, engineers and cosmonauts of the two countries carried out in this connection an extensive programme that is of great theoretical and practical significance.

Though Mongolia's national, original culture is very old, never before, throughout the many centuries of its history, has popular involvement in society's intellectual life been so universal and intensive as now. To be credited for the present high cultural levels is the ramified chain of institutions for cultural enlightenment set up throughout the country, the promotion of the information media, including television, and the spread of book-publishing.

Meanwhile the widespread amateur arts have risen to a new and higher level.

Professional literature and art are flourishing. Nowadays Mongolian authors are popular abroad as well, not only at home. Mongolian art is continually enriched with new striking paintings, sculptures, musical compositions, plays and films. Mongolia's truly national culture has earned well-deserved prestige in many lands.

Зөвлөлтийн сансрын «Союз-39» хөлгөөр Ж. Гуррагчаа, В. Жанибеков нар хамтын нислэг хийсэн явдал монголын ард түмний бахархал болов. Энэ нислэг, монгол-зөвлөлтийн эвдэршгүй найрамдал, «Интеркосмос» программын хүрээнд социалист орнуудын хамтран ажиллаж байгааг яруу тодоор харуулав

The Mongolian people take full pride in the joint manned space flight of their countryman Zh. Gurragcha and Soviet cosmonaut V. Dzhanibekov aboard Soyuz 39. *This flight demonstrated the great successes of cooperation between the socialist countries within* Interkosmos *programme*

Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дээд шагналыг сансрын ах дүү нарт олгов. Энэ бол бидний баяр бахдал, сэтгэл зүрхний хайр юм

Winning our heartfelt love and admiration, the space duo merited distinguished awards of the Soviet Union and Mongolian People's Republic

Эрдэм мэдлэг, бүтээл туурвилын соньхон бөгөөд баяр баясгалант ертөнцийн үүд хаалга Монголын үр хүүхдэд цэлийтэл нээлттэй байдаг юм

The doors to the shining, exciting world of knowledge and creative work lie wide open before the children of Mongolia

Бидний үрс
Биднийгээ дууриаж
Биднээ улам дээртэн баяжуулж
Биднийхээ араас өсөж өндийж
Бидний хүслийн туйлд хүрцгээнэ.
Биднээс өмнөх үеийн сайхан мөрөөдөлтэй
Бидний хүслийг нэмэн нийлүүлээд
Биднээс хойших үеийн зүг рүү
Биднийхээ илч болон
Бидний үрс очно.

Л. Түдэв

Sons and daughters follow in our footsteps
And do as we did, only better, braver;
They look out 'cross our land of hill and steppe
And cherish dreams of fortune's future favours.

L. Tudev





Улаанбаатар дахь
В. И. Лениний музей

The Lenin Museum in
Ulan Bator

Монгол Улсын Их Сургуулийн хичээлийн гол байр

Main building of the Mongolian State University



Монголын нийслэл дэх дээд сургуулиудад ах дүү социалист болон бусад орны охид, хөвгүүд суралцдаг юм

In the student body of Mongolia's capital one sees young men and women from the fraternal socialist countries and other lands

БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн хүрээлэн, лабораторид эрдэмтэд мэдлэгийн үндсэн бүх салбарт шинжилгээ явуулж байна

At the laboratories and institutes of the Academy of Sciences of the Mongolian People's Republic scientists conduct research in all basic fields of study









БНМАУ-ын Шинжлэх ухааны Академийн одон орныг шинжлэх газрынхан үндэсний ба олон улсын программаар их ажил гүйцэтгэдэг юм

The staff of the Mongolian Academy of Sciences Observatory are going all out to implement a far-reaching national and international programme







Тус оронд орчин үеийн соёлыг хөгжүүлэхийн хамт монголын ард түмний соёлын өвийг гамтай хайрлан хадгалдаг

In the current effort to advance the cultural levels of the Mongolian people every care is taken to jealously preserve the nation's cultural heritage

Эртний Монгол улсын нийслэл Хархорин дахь Эрдэнэзуугийн хийд. Монголын уран барилгын энэ гайхамшигт дурсгал болсон барилгад монголчуудын шашин шүтлэгийн ёс горимтой холбогдсон маш баялаг үзмэр хадгалагдаж, олон жуулчны сонирхлыг татаж байна

The Erdene-dzu lamasery-museum is located in Kara-Korum, once capital of the ancient state of Mongolia. Preserved within this gem of national architecture is a magnificent collection of religious ritualistic items that excite the imagination of numerous tourists







Эртний монголын уран
*барилгач, баримал*ч*,*
уран зураачдын бүтээлийг
манай үеийн хүмүүс
ч бахдан хүндэтгэдэг билээ

The handiwork of the
architects, sculptors and
artists of the past continues to
arouse enthusiastic admiration



Монголын зураачдын гол сэдэв нь орчин үеийн хүний дүр, улс орны дотор гарч буй социалист өөрчлөлтүүд юм

Today's artists and sculptors concentrate on limning the image of their contemporary and on depicting the socialist transformations that have been brought about in Mongolia



БНМАУ бол олон улсын номын үзэсгэлэн-яармагт байнга оролцогч улс юм

Mongolia is a permanent participant at international book fairs





Монголд сонин, сэтгүүл, ном зэрэг хэвлэлийн бүтээгдэхүүн жил ирэх тутам өсөн нэмэгдсээр байна. Монголын уншигчид зөвлөлтийн зохиолчдын туурвисан зохиол бүтээлийг онцгой сонирхдог юм. Орос болон бусад хэлнээ орчуулагдсан монголын зохиолчдын ном зохиолын тоо ч өссөөр байна.

The circulation of Mongolia's periodicals and printings of books and other literature increase with every year. Soviet authors are particularly popular with the country's reading public. At the same time more and more works by Mongolian writers are published in translation in Russian and other foreign languages.

БНМАУ-ын Ардын дуу бүжгийн улсын чуулгын жүжигчид тус улсын бүх аймгаар үл барам дэлхийн олон улс орноор явж, очсон газар бүрдээ амжилттай тоглодог юм

The Mongolian People's Republic State Song and Dance Group has toured extensively with great éclat both at home and abroad

Үндэсний «Учиртай гурван толгой» дуурийг дурлан үздэггүй монгол хүн гэж байдаггүй. Энэ дуурь олон арван жилийн турш нийслэлийн театр, хөгжимт драм, ардын театрын тайзнаа үргэлж гарч байна

Amidst the Sad Hills *is a national opera, which enjoying high, nationwide esteem and popularity, has been for years a permanent fixture among performances billed not only by the Ulan Bator Opera House, but also by other professional and amateur operatic troupes*

Монголчууд эрт үеэс эдүгээ хүртэл дуу дуулах гайхам авьястай юм

Solo and choral singing, the oldest of the country's performing arts, has always been extremely popular





Монгол бол үндэсний хэлбэртэй, социалист агуулгатай соёл цэцэглэн хөгжсөн, урлагийн өвөрмөц авьяастнаар баялаг орон

Mongolia, a land of a flourishing culture, that, while national in form, is socialist in content, has many talented performers







Дарханы театр бол тус орны мэргэшлийн хамгийн залуу хамтлагуудын нэг мөн

The Darkhan Drama Company is among the country's youngest professional troupes

Монголчууд циркт дуртай

The circus is a top favourite



Үндэсний телевиз Зөвлөлт Холбоот Улсын «Орбит» системийн шууд нэвтрүүлгийг монголын хотуудын оршин суугчид төдийгүй олон аймаг, сумын төвийн хүмүүс ч үзэж байна

In both town and country televiewers watch, besides national TV programmes also Soviet TV programmes beamed via the Orbita satellite relay network



Жил бүрийн долоон сард
Зуны улирал найртай сайхан
Зүйл бүрийн бодис дэлгэрэхэд
Зугаацан наадахад тааламжтай
Богд уулын бэл дор
Туул голын хөвөөн дээр
Түвшин сайхан Буянт ухаад
Туйлын сайхан наадам болно.

Д. Нацагдорж

Every year in July
When season's days are clear and sunny
And Nature drinks deep, alive
And joy fills hearts until they're humming,
Beside Tola River
And to the slopes of Mount Bogdo-Ul
Festive, people congregate
A carnival gay to celebrate

D. Natsagdorzh





НААДАМ — БҮХ АРД ТҮМНИЙ БАЯР
NADOM—THE NATIONAL HOLIDAY

Наадам бол монголчуудын хамгийн баясгалантай саруул гэгээн баяр юм. Тус оронд жил бүр, ардын хувьсгал ялсан ойгоор наадам хийдэг.

Улаанбаатарт өглөөнөөс эхлэн хотын төв талбайд цэргийн парад явж, дараа нь биеийн тамирчдын болон олон мянган хүний сүр жавхлант жагсаал болдог юм. Үдээс хойш наадмын ажиллагаа цэнгэлдэх хүрээлэн, амралт, соёлын цэцэрлэгт хүрээлэн, уран сайхны тоглолтонд зориулсан талбай, театрт шилжинэ.

Наадмын төрөл бүрийн соёл урлаг, биеийн тамирын программын дотроос эрт дээр үеэс уламжлалтай «эрийн гурван наадам» онцгой суурь эзэлнэ. Үндэсний бөх, сур харвах, морь уралдахыг монголчууд ингэж нэрлэдэг юм. Одоо үед наадмын энэ тэмцээнд дан ганц эрэгтэйчүүд оролцдогоо нэгэнт больжээ. Сур харвахад эмэгтэйчүүд оролцдог бөгөөд хурдан морь унаж түмний эхийн нуруун дээр түрүүлэн ирэгсэдийн дотор зургаа-долоон настай охид байх нь цөөнгүй.

Наадмын программаас голчлон их сонирхдог нь монголчуудын хамгийн дуртай бөгөөд энд тэндгүй дэлгэрсэн спортын төрөл болох үндэсний бөхийн барилдаан юм. Энэ тэмцээнийг тун гойд сайхан дүрэм горимтой эхэлдэг. Олон зуун бөх биедээ таарсан өнгө өнгийн зодог шуудгаа өмсөж цэнгэлдэх хүрээлэнгийн ногоон талбай дээр дэвсээр гарч ирнэ. Мөн түүнчлэн торгон дээлтэй засуулууд нь гарч ирээд түмний манлай хүчтэн болсон нэр цуут аваргуудын цолыг наадамчин олны өмнө уянгалуулан дуудна. Унасан бөх хасагдах тул энэ тэмцээн олимпийн системээр явагддаг юм. Барилдахад цаг тогтоодоггүй, жингээр ялгадаггүй, орхисон нь үлдсээр нэг бөх түрүүлэх учиртай тул тэмцээний болзол үнэндээ маш хэцүү бөгөөд хамгийн чадалтай ганц хүнийг шалгаруулах, шалгарсан арга юм. Хоёр өдрийн турш үргэлжилдэг энэ тэмцээнийг гагцхүү хамгийн сайн бэлтгэлтэй, бяр, мэхтэй тамирчин даван туулж чадна. Тав давсан бөхөөс эхлэн амжилттай барилдсан тамирчдад начин, заан гэх мэт цол гуншин олгодог. Түрүүлсэн бөхөд Арслан буюу Аварга цол олгоно.

Сур харвахад мэргэн харвалт, бяр чадлыг эрхэмлэнэ. Бай оноход азай буурал өвгөд уухайлцгаана.

Хурдан морины уралдаан үнэхээр гайхам хосгүй сайхан санагдана. Тав-зургаан настайгаас эхлэн жижигхэн охид, хөвгүүд унасан олон зуун морь нэгэн зэрэг гараан дээрээс туурай нижигнүүлэн давхина. Морь унасан хүүхдийн насны ялгаа морины эзлэх байранд ямар ч нөлөөгүй. Түрүүлэгсдийн нэр алдрыг өндөр дуугаар наадамчин олонд зарлан сонсгоно. Заншил ёсоор түрүүлж ирсэн морины хондлойг айргаар мялаана.

Ер нь наадамд түрүү магнайд шалгарагсдыг цоллох, шагнах ёс горим сүрлэг сайхан!

Nadom is the Mongolian's best-loved, happiest holiday. *Nadom* is a nationwide popular annual event, which coincides with celebrations of the anniversary of the Mongolian People's Revolution.

In Ulan Bator, the capital, *Nadom* starts on the central square in the morning with a military march-past and massive popular demonstration, the highpoint of which is a colourful gymnastics parade. In the afternoon and evening, sports grounds and stadiums, parks and gardens, open-air stages and playhouses furnish the venues.

Highlight of *Nadom's* diverse athletics and cultural bill are the traditional *Three Games for Men,* the local name for a three-in-one gymkhana featuring contests in national-style wrestling, archery and horse-racing. Now, no doubt, the name should be changed as female archers also compete, while in the horse races it is often the case for dare-devil girl jockeys to carry off the prizes.

Nonetheless the central event is the contest in national-style wrestling, long the top popular sport, which no Mongol will miss. In the picturesque pageant opening the contest, hundreds of competitors, garbed in gay, multi-coloured attire run out onto the stadium's green sward, where seconds wearing the national silk *deli* robes introduce the more famous wrestlers and declaim their feats. The contest is conducted on the Olympic system, with the loser excluded from further competition. Naturally, only a well-trained athlete can stand the stresses of this two-day-long contest. The first three places carry with them such titles of esteem as *Nachin* (Falcon), *Zan* (Elephant), and the top one of *Arslan* (Lion) or *Avarga* (Titan).

As for the archery competitions, a chorus of bearded ancients extols the first marksman to score the bull's eye.

The horse races make a grand, inimitable and exciting show. Hundreds of riders, boys and girls up from the age of five—with, incidentally no handicaps for age, as all are considered equal—take the start simultaneously. Powerful loudspeakers broadcast the name of the winner, which is caught up by thousands of throats. In full accordance with custom the prize-winning horse is sprinkled with *koumyss*.

The ceremonies staged for the winners of the *Nadom* contests, add up to a truly fantastic, breath-taking sight!

МОНГОЛ АРДЫН
ХУВЬСГАЛЫН
60 ЖИЛ

Ардын хувьсгал ялсан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүх ард түмний баярын өдөр Д. Сүхбаатарын нэрэмжит талбай ийм байдалтай харагдана

Sukhe-Bator Square in Ulan Bator on People's Revolution Day, the national holiday of the Mongolian People's Republic

Өссөн төрсөн бидний үндэсний хайртай нутаг
Өнгөлзөгч дайсан ирвэл үтэр өшиглөн хөөнө.
Хувьтай энэ орондоо хувьсгалт улсаа мандуулж
Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяаг байгуулъя.

Д. Нацагдорж

With intent good and peaceful our own way we wend,
The power of the people uphold and defend.
But should brazen enemy dare us to attack,
We have the strength in sinews to beat his hordes back.

D. Natsagdorzh

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал

Yumzhagiin Tsedenbal, General Secretary of the Central Committee of the Mongolian People's Revolutionary Party and President of the Presidium of the Great People's Khural

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Бүхэнх ард нь цугларaад
Бөх наадмаар сонирхолдон
Бүжиг хөгжмөөр баясалдана.

Д. Нацагдорж

On high, scarlet banners wave
And gay strains of music fill the air.
Inscribed on every face
A loving pride in our country fair.

D. Natsagdorzh



Одоо, ирээдүйн аварга

The champion and his successors

FRIENDSHIP

Үндэсний бөхийн барилдаан бол монголчуудын хамгийн дуртай, хамгийн их дэлгэрсэн спортын төрөл юм. Түүнийг үзэгчид баяр баясгалан бялхсан байдаг.

National-style wrestling is a top favourite that excites both young and old



Хулан зээрийн сүргийг уралдууланхан байдаг тал минь
Хурдан хөлгийн унагыг хатирууланхан байдаг тал минь.

Л. Түдэв

The riders gallop, with expanse dispute,
Racing to radiant, remote objective.

L. Tudev



ХОТЫН
АВАРГА

МОНГОЛ ОРОН

MONGOLIA

МОНГОЛИЯ

Фотоальбом

Перевод с русского языка

Составитель и автор текста К. Б. БОЛДОХОНОВ

Макет и оформление Б. К. УШАЦКОГО

Специальная фотосъемка А. В. ЛИБЕРМАНА

Перевод на монгольский язык Д. АЛТАНХОЯГА, С. ЛОЧИНА, Д. ЛХАМЖАВА

Перевод на английский язык А. ШКАРОВСКОГО-РАФФЕ

4/2 5662 (8.50)

Б $\frac{4911020000-118}{027(01)-83}$ 1-82